



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/31/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: Tsedenkham@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 213
танай _____ ны № _____ т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Н.БАТЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2025-2027 оны хэлэлцээрийг шинэчлэн байгуулах, Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулж, хөгжил оролцоог хангахад чиглэсэн "Зөв өрх 20" төлөвлөгөө, Төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн хүрээнд шинээр ажлын байр бий болгох, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэдсэн чуулган зохион байгуулж, нийгмийн идэвх оролцоог хангах зэрэг томоохон арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж ажилласан байна.

6326050372

Бусад асуудлын хэсэг

Нийгмийн халамж, цалин хөлстэй холбоотой 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, "Эхийн алдар" одонтой эхийн мөнгөн тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792.0 мянган төгрөг болгосон, Ахмад настны тухай хуульд ахмад настан хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болох хууль, эрх зүйн өөрчлөлт мөрдөгдөж эхэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

The image shows a handwritten signature in black ink over a pink rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name of the State Audit Agency and the date of the document.

Д.БАТЦОГТ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	85,457.4	141,530.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,435,741.9	1,450,350.2
	Нийт хөрөнгийн дүн	1,521,199.3	1,591,880.3
	Нийт өр төлбөрийн дүн	-	3,224.7
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,521,199.3	1,588,655.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,521,199.3	1,591,880.3
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,232,367.5	1,931,276.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,960,202.6	1,863,819.7
	Үйл ажиллагааны үр дүн	272,164.9	67,456.3
	Үйл ажиллагааны бус үр дүн	(224,865.0)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	47,299.9	67,456.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,473,899.4	1,521,199.3
	Тайлант оны үр дүн	47,299.9	67,456.3
	Эцсийн үлдэгдэл	1,521,199.3	1,588,655.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,847,195.8	1,811,970.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,804,831.5	1,824,170.2
	Үйл ажиллагааны ЦМГ	42,364.3	(12,200.0)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	39,244.3	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	81,608.6	(12,200.0)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,080.0	12,200.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,200.0	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,683,864.9	1,494,645.0
	Урсгал зардал	1,683,864.9	1,494,645.0
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,683,864.9	1,494,645.0
	Улсын төсвөөс санхүүжих	1,507,819.2	1,373,636.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	176,045.7	121,008.7

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь эрхэм зорилгоо “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд оновчтой хүргэх, чанар, хүртээмж, үр ашгийг сайжруулах замаар иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрахад чиглэсэн эрсдэлд суурилсан хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ.

- Салбарын хууль тогтоомж, бодлого шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх, дотоод, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- Төсөв, санхүүгийн ил тод байдал, хариуцлага, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн сахилга батыг чанд мөрдөх, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд хяналт тавих.
- Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг хангахад ажилтан, ажил олгогчийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх замаар тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ядуурлын түвшинг бууруулах.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргатай 10 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.3 хувь, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилт, 97 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 85.9 хувьтай үнэлүүлэн “маш сайн” үнэлгээ авсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ

худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга;

- Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Нийгмийн халамж, цалин хөлстэй холбоотой 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, “Эхийн алдар” одонтой эхийн мөнгөн тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792.0 мянган төгрөг болгосон, Ахмад настны тухай хуульд ахмад настан хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болох хууль, эрх зүйн өөрчлөлт мөрдөгдөж эхэлсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Тайлант онд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2025-2027 оны хэлэлцээрийг шинэчлэн байгуулах, Зорилтот бүлгийн өрхийн гишүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулж, хөгжил оролцоог хангахад чиглэсэн “Зөв өрх 20” төлөвлөгөө, Төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн хүрээнд шинээр ажлын байр бий болгох, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэдсэн чуулган зохион байгуулж, нийгмийн идэвх оролцоог хангах зэрэг томоохон арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж ажилласан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн

агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс хугацаа болоогүй 5 мэдээлэл байна. 178 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 1,930.8 сая төгрөгийн 41 орлогын, 88.2 сая төгрөгийн 14 зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж ажилласан байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгоходоо хууль, журмын хэрэгжилтийг хангах.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 25.8 сая төгрөгийн алдаа, зөрчил¹ илэрснээс 12.0 сая төгрөгийн 4 алдааг залруулж, залруулагдаагүй 11.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2.1 сая төгрөгийн алдаанд 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 13.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5.8 сая төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

1. Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгоход тавигдах нөхцөл хангаагүй албан хаагчид 8.0 сая мөнгөн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн нэмэгдлийн цалин, урамшуулалд 3.7 сая төгрөгийг 3 албан хаагчид олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 42, 43 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам", санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1.1: Ээлжийн амралтын тодорхой хоногийг биеэр амралт эдлээгүй төрийн албан хаагчдад мөнгөн олговор олговор олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 61.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль, журмын хэрэгжилтийг ханган ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, зайлшгүй ажлын шаардлага гарсныг нотлох шаардлага хангасан баримт бичиг, эрх зүйн баримт бичгийг үндэслэн шийдвэрлэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант хугацаанд 1.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгааны маягтаар баталгаажуулаагүй	1	1.2			1	1.2	1	1.2				
Тайлант хугацаанд 0.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцооны үлдэгдлийн баталгааны маягтаар баталгаажуулаагүй	1	0.2			1	0.2	1	0.2				
Цалингийн зардлаас шууди зардал бүртгэсэн.	1	8.9			1	8.9	1	8.9				
Цалингийн зардалтай холбоотой бичилт болон АО-ын НДШ, даатгуулагчийн НДШ бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан.	1	1.0			1	1.0	1	1.0				
Газрын нэгдсэн удирдлагын нэгдсэн цахим системтэй газрын нэгж талбарын тоо, газрын төлбөрийг тулгаагүй.	1	0.7			1	0.7	1	0.7				
Дүн	4	12.0			4	12.0	4	12.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль, журмын шаардлага, нөхцөл хангаагүй төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгосон.	1	8.0	1	8.0								
Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг орлон гүйцэтгэсний нэмэгдлийг илүү олгосон.	1	3.7	1	3.7								
Ээлжийн амралтын тодорхой хэсгийг биеэр эдлээгүй албан хаагчдад мөнгөн олговор олгосон.	1	2.1					1	2.1				
Дүн	3	13.8	2	11.7	-	-	1	2.1				